

МАЛЧИД БА ХУВЬСГАЛЧИД

Ч.Тамир

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Социологийн тэнхим

Өгүүллийн товч утга: 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалд оролцсон партизануудын намтар, дуртгалд контент анализ, амьдралын түүх, кейс стади аргаар дүн шинжилгээ хийж хувьсгалын өмнөх нөхцөл байдал, шалтгаан, хөдөлгөгч хүч, хувьсгалчдын социал дүр төрх зэргийн талаар өгүүлжээ.

Түлхүүр үгс: хувьсгалын хөдөлгөгч хүч, хувьсгалчид, ардын журамт цэрэг, партизан, малчин, хөдөлмөр, социал дүр төрх,

1. Хувьсгалын хөдөлгөгч хүч хэн байсан вэ? Америкийн нэрт социологич Н.Смелзер Францын хувьсгалын тухай ийнхүү бичжээ.

1789-1794 оны Францын хувьсгал түүхчдэд ховсдон нөлөөлж, бараг 200 жил үргэлжилж байгаа сэтгэлийн хөдөлгөөнт маргааныг үүсгэжээ. Энэ маргаан зарим талаараа тэр хувьсгалын 1789-1794 оныг дуусталх хугацааны хөдөлгөгч хүчний тухай асуудлыг хөнджээ. Бастилийг эвдлэн авахаар цугларч, Версаль дахь хааны ордны зүг уурссан, асар их олноор хөдөлж, XVI Людовик ба залуу хатан хааныг цаазлахад хөөрөн баярлаж байсан энэ хүмүүс хэн байв?

Зарим түүхчид тэднийг ардчиллын шинэ эринийг тунхаглахад тус болсон жирийн хүмүүс-баатрууд гэж үзсэн. Зарим нь тэднийг тэнүүлчид, гэмт хэрэгтнүүд, анхиагүй амьтад, ажилгүйчүүд буюу францын нийгмийн шаарууд гэж үзэж байв. Энэ хоёр чиглэлийг баримтлагч эрдэмтэд санамсаргүй гэрчүүдийн дурдатгалд, тэр сэтгүүлчид, улс төрчдийн хэлсэн үг зэрэг хомсхон мэдээлэлд тулгуурлан өөрсдийн үзлийг саяхан болтол хамгаалж байв. Тэр эх булаг нь найдваргүй юм.

1950-иад оны эцсээр түүхч Жорж Руде /1959/ энэ асуудлыг ямар нэгэн хэмжээгээр тодруулахыг оролджээ. Үүндээ Руде "шааруудын" тухай Густав Лебоны үзлийг баримтлагчдыг харгалзан үзсэн боловч мэдээллийн илүү найдвартай шинэ эх булаг олох гэж эрмэлзжээ. Түүнийг тэрбээр францын хувьсгалын үеэс хадгалагдсан цагдаагийн архиваас олжээ. Энд алагдсан, шархадсан, баривчлагдсан эсвэл ердөө байцаагдсан хүмүүсийн тухай мэдээ баримт байжээ. Францын цагдаагийн газар хэргийн нарийн учрыг сонирхдогоороо алдартай бөгөөд хувьсгалын үед үлэмжхэн олон талын мэдээ сэлтийг цуглуулсан байна. Цагдаагийн газар дуудагдсан хүмүүсийг удтал байцааж тэдний ажил төрөл, хаяг, төрсөн газар, нас, бичиг үсгийн мэдлэг, өдүүлсэн гэмт хэргийг протоколд тэмдэглэсэн байв.

Руде эдгээр архивыг нарийвчлан судалж хувьсгалт олон түмний заримын нь тухай мэдээ зангийг цуглуулжээ. Ямар хүн татагдан орсон, хүмүүс яагаад хувьсгалт үйл ажилд оролцсон, хэн тэднийг удирдаж байсныг сонирхжээ. Рудегийн судалгаа нь Лебоны онолыг шинээр тунгаан харуулж, түүнийг ноцтой дутагдлыг илрүүлжээ. Тэрбээр бөөн олон нь нэг маягийн хүмүүсээс бүрдэж байгаагүй, түүнд нийгмийн янз бүрийн бүлгийн төлөөлөгчид оролцож байсныг харуулжээ. Ихэнхи худалдаачид, гар урчууд байв. (Н.Смелзер, 2001).

Дээрхээс харахад Жорж Руде цагдаагийн архиваас хувьсгалд оролцсон хувь хүн бүрийн талаархи нарийвчилсан мэдээллийг олж улмаар Францын хувьсгалын оролцогч бүрийг нарийвчлан судлах замаар дүгнэлт хийжээ. Тиймээс эл аргачлалыг ашиглан бид 1921 оны үндэсний ардчилсан хувьсгал түүний хөдөлгөгч хүчнийг нарийвчлан судлахыг зорьсон юм. Чухамдаа хутагт хувилгаан биш, угсаа залгамжилсан язгууртан ч биш жирийн л ард гаралтай хувьсгалчдыг дагаж гаминтай тэмцэж, цагаан цэргийг цохиж тусгаар тогтнолоо эргүүлэн авчирсан мөн цаашид нийгмийн хувьсгал хийхэд гар бие оролцсон хүмүүс ямар хүмүүс байв? Марксист үзэл баримтлалыг ойлгосон дарлагдсан анги байв уу? Жирийн үндэсний үзэлтэй эх орончид уу? Аль эсвэл Лебоны бичсэн шиг маргинал бүлэг нийгмийн хог шаарууд байв уу?

2. Судалгааны зорилго, ба зорилт: Орчин үед социологи ба түүхийн шинжлэх ухаан ихээхэн уялдаа хамааралтай хөгжиж байна. (Тамир.Ч, 2002) Ялангуяа түүхийн социологийн шинжилгээний ажилд түүхийн үйл явцыг бүрдүүлэгч нэгж, хувь хүний төвшинд (Ж.Болдбаатар, 2003) судлах оролдлого амжилттай хийгдэх болсон, энэ нь асуудлыг илүү нарийвчлалтай, илүү тодорхой, илүү гүнзгийрсэн төвшинд судлах шаардлагатай байгаа өнөөгийн цаг үеийн хэрэгцээ шаардлагад зүй ёсоор нийцэх юм. Академич Ж.Болдбаатар энэ тухай

Түүхийн олон асуудлыг мушгин гуйвуулах, үгүйсгэх, **эзэнгүйдүүлэх**, түүхэн гаргалгааг гоёж чимэх, **бэрхшээлтэй талыг орхигдуулах** зэргээр түүхийн "цагаан толбо"-ыг үүсгэж байна. (Ж.Болдбаатар, 1999)

гэжээ. Тиймээс энэхүү бэрхшээлийг давж туулахын тулд түүхт хүмүүсийн намтрыг судлах талаар манай түүхчдийн хийсэн ажил сүүлийн үед ихээхэн амжилт олоод байна. (Ч.Болдбаатар, 2004) Энэхүү судалгааны ажлын зорилго бол 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын үйл явцад оролцогч бүрийн социал статус, эрхэлж байгаа ажил, орлогын эх сурвалж, гэр бүлийн байдал зэргийг тусгайлан нарийвчлан судлахыг хичээсэн болно. Ингэж аливаа асуудлыг хувь хүний зан үйлээс буюу дороос нь дээш судлах зарчмаар судалгаа хийх нь улс төр, түүхийн социологийн судалгааны үндсэн зарчмын нэг (Ч.Тамир, 2004) билээ.

3. Судалгааны арга: Бид энэхүү судалгаандаа контент анализын аргыг ашигласан. Ингэхдээ ардын журамт цэргийн дуртгалыг контент анализын аргаар ангилж социологийн мэдээллийг боловсруулдаг программаар (SPSS) боловсруулж шинжилгээ хийв. Бичиг баримт судлах уламжлалт аргаар судлах гэж байгаа асуудалтай холбоотой гадаад болон дотоодын сэтгүүл, судалгаа, шинжилгээний ном зохиол, илтгэл зэргийг судлан шинжлэв. Дээрх хоёр аргатай хослуулан амьдралын түүхийн аргыг (В.Отгоннасан, 2004), кейс стади аргатай хослуулан ашиглав. Ингэж дуртгалыг тухайн хувь хүний амьдралын түүхтэй холбон үзсэнээр илүү бодитой бүрэн зураглал харуулахыг хичээсэн.

Энэ судалгаа эхлэхээсээ дуусах хүртэл ашиглаж байгаа мэдээлэл маань хэр зэрэг үнэн магадтай бол гэсэн асуулт ямагт тархинд эргэлдэж, нарийвчлах тусам цаашид судлах ёстой зүйлсийн жагсаалт ихэсч байв. Тиймээс бид олон асуултыг дараа дараагийн судлаачдад үлдээсэн.

4. Сэдвийн судлагдсан байдал: Судалгааны эх сурвалж гэж хэлж болохуйц материал гэвэл "Ардын журамт цэргийн дурдатгалууд" бүтээлийг 1961 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс эрхлэн Д.Гонгор, Г.Цэрэндорж нар бэлтгэж, Ш.Нацагдорж, Х.Пэрлээ нар найруулан 203 хүний дэлгэрэнгүй дуртгалыг багтаан хэвлүүлжээ. Бүтээлийн оршилд нь оролцогчдын баримт дээр тулгуурлан ард түмний хөдөлгөөн нь орон даяар өрнөсөн том үйл явц байсан гэдгийг дурдсан.

1921 онд ...явуулсан тэмцэл нь тус орны аль нэг өнцөг буланд цэргийн ямар нэгэн анги нэгтгэлүүдийн хооронд болсон жижиг сажиг тулалдаан биш, **нийт Монгол орныг хамарсан** (тодруулав Ч.Т), харийн дайсны эсрэг монголын бүх ард түмний ариун шудрага дайн, жичхэн эрх чөлөөний хувьсгал байв. (Ардын журамт цэргийн дурдатгалууд, 1961)

Дараагийн хэсэгт төв ба хойд, баруун зүгийн нутагт тэмцлийн гол явагдсан, зүүн аймгууд энэ жагсаалтанд багтаагүй гэсэн санааг өгүүлсэн нь нийт монгол орныг хамарсан гэсэн өмнөх дүгнэлттэй зөрчилтэй байв.

...бүх ард түмний тэмцэл нь хөлсний зарц дээрэмчин цэргийн эсрэг явуулсан

зэвсэгт тэмцлийн гол нь **монголын төв ба хойт, баруун зүгийн нутаг** болох нийслэл Хүрээ, одоогийн Сэлэнгэ, Булган, Хөвсгөл Завхан, Ховд, Баян-Өлгий аймгийн нутагт явагджээ. (Ардын журамт цэргийн дурдатгалууд, 1961)

Улмаар энэ хувьсгалд нийгмийн бүхий л давхраа оролцсон гэж дүгнэсэн. Ингэж хөдлөх хүчин нь жирийн малчин ардууд байсан гэж хэлсэн ч нийгмийн бүхий л давхраа үүнд баян чадалтан, үндэсний үзэлтэн, язгуурын тайж, ноёд гэдгийг дурдсан нь цаг үедээ тун зоримог алхам байсныг хэлэх хэрэгтэй.

Энэ тэмцэл тэр үеийн Монголын **нийгмийн бүх давхраа** (жирийн малчин ард...хэрмэл цагаачин, хот суурины хүмүүс, баян чадалтан, үндэсний үзэлтэн, язгуурын тайж, бичиг цэргийн түшмэд, лам нар, зарим нэгэн засаг ноёд)-ны хүмүүс оролцсон байна. Гэвч хувьсгалын **хөдлөх хүчин нь Монголын жирийн малчин ардууд** байлаа. (Ардын журамт цэргийн дурдатгалууд, 1961)

Энэ номыг ашиглан нэрт монголч эрдэмтэн О.Латтимор судалгаа хийсэн. Номонд хэвлэгдсэн 203 хүний дурдатгалыг хамарсан бөгөөд 1962 онд хэвлүүлсэн “Нүүдэлчид ба хувьсгалчид” номынхоо 5-р бүлэг буюу “Малчдын хувьсгал” гэсэн гол хэсгийг эл судалгааны ажил дээр тулгуурлан бичжээ. Тэрээр партизануудын мэдээллийг барагцаагаар 15 орчим үзүүлэлт, 60 гаруй шкалтайгаар (нас, боловсрол, бичиг үсэг, харьяалал, гэр бүлийн байдал, алба хааж байгаа байдал, хийдэд шавилсан байдал, эрхэлж байгаа аж ахуй, төрсөн нутаг ус, байлдаж байсан туршлага, хувьсгалд ухамсартай дагалдан орсон эсэх, намд элссэн эсэх, нийгмийн давхраа гм.) задлан нэг стандартанд оруулж нэгтгэж дүгнэжээ. Судалгааны мэдээллийг боловсруулах орчин үеийн шинжлэх ухааны ололт, компьютер программ хангамж ашиглах бололцоотой өнөөдрийн төвшинтэй харьцуулбал О.Латтимор абугайн судалгаа тойм төдий л юм, гэвч дээрх мэдээллийг задлан шинжилсэн арга зүй, гарсан үр дүн нь гайхамшигтай байлаа. Тэрээр олон баримт сэлт, үйл явдлыг тоочоод орхисонгүй Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, С.Магсаржав нарын гурван хүний амьдралын түүхтэй уялдуулан нарийн зураглалыг харуулсан. Ингэж түүхийн үйл явцыг судлахдаа нэг эх сурвалжийн бүхэл дүгнэлтээс татгалзаж нэгжийн төвшинд асуудлыг нарийвчлалтай, тодорхой, цогцолбороор нь судлах ажлыг О.Латтимор эхлүүлжээ. Хувьсгалын хөдөлгөгч хүч болсон партизануудын социал дүр төрхийг тэрээр ийнхүү тодорхойлжээ.

/Партизануудын Ч.Т/ хүмүүсийн гуравны нэг орчим нь үндэсний арми, хошуу тамгын газар, цэрэг цагдаа болон Сибирийн хилийн дагуу харуулд алба хааж байжээ. Хэдэн арваад нь залуудаа хүрээ хийдэд шавилан сууж байв. Бас нэлээд нь өнчин үлдсэн, эсвэл эцэг, эх нь өсгөж дийлэхгүй учир хүнд өргүүлсэн намтартай. Арав, хориод хүн дагнан, эсвэл хавсран тариалан эрхэлж байжээ. Бичиг үсэг үл мэдэх явдал давамгайл байсан нөхцөлд сэхээтний доод давхарга ч хамрагдаж байсныг төрийн болон цэргийн газарт бичээч хийж явсан есөн хүн гэрчилж байна. ...Тэдгээр хувийн дуртгалд байн байн давтагдаж гарч байгаа хүмүүс гэвэл хөлсний малчин, анчид, жин тээгчид, хуучин тээврийн газрын тэрэгчин, мөн өртөө замын улаачид болно. Мөн өөрийн гэсэн хэдэн малтай боловч аж ахуйн хувьд биеэ даасан, бололцоотой улсыг ангилалд оруулсан ч болно, эсвэл тусад нь тооцсон ч болно. (О.Латтимор, Нүүдэлчид ба хувьсгалчид, 1994)

Мөн партизануудыг баруун ба зүүн монгол гэж уламжлалт хэлбэрээр хуваан үүний харьцааг гаргаж түүхийн үндэстэй тайлбарласан.

Партизануудын тал хувь нь зүүн Монголоос, гуравны нэг нь баруун нутгаас, мөн үлдсэн арван таван хувь нь энд тэндээс, зарим нь бүр хаанаас ч юм мэдэгдэхгүй ажээ. Ийм харьцааг үндэстэй гэж үзэж болох юм. (О.Латтимор, Нүүдэлчид ба хувьсгалчид, 1994)

Улмаар хувьсгалын лидерүүд ба идэвхтэнүүд, жирийн гишүүдийн харьцааг нарийн гаргаж хувьсгалын хөдөлгөгч хүчний талаар өөрийн дүгнэлтийг хийжээ.

Зүүн нутгаас гаралтай жирийн партизанууд дунд Сүхбаатар, Чойбалсанг **анхнаасаа ухамсартай дагалдсан хүмүүс тун цөөн** байв. Ерөнхийд нь авч үзвэл тэдний олонхи нь **хувьсгалд хөдөлгөөн цагаа олж байгуулагдсан учраас л нэгдэн орсон** ажээ. Нөгөө талаас баруун нутгаас гаралтай нь тооны хувьд гуравны нэг орчим байсан боловч Сүхбаатар, Чойбалсангийн нэр гарахаас аль өмнө «баруун зүгийн товхиноулагч жанжин» хэмээн алдаршсан нэг л хүнийг дагахаар сэтгэл шулууджээ. Хэрвээ тэрээр хувиа бодсон бол өөрийгөө цэргийн хүний хувьд «тахин шүтүүлэн» зүүн Монголчуудын байгууллагуудтай зөрчилдөж мэдэх байв. Түүний сонгосон зам нь Монголын хувьсгалыг ухан олгоход нэн тустай. Тэр хүн бол жигтэй сонин намтартай, сайхан бодолтой зарим үед ширүүн дориун зантай Магсаржав байсан юм. (О.Латтимор, Нүүдэлчид ба хувьсгалчид, 1994)

Ингэж тэрээр Магсаржавын бодит бололцоог өндрөөр үнэлэхийн зэрэгцээ нийгмийн хувьсгалыг эсэргүүцэж чадах цорын ганц нэр дэвшигч байсныг тэмдэглэсэн. Үүн дээр үндэслэн гадны түрэмгийлэгчдийн эсрэг хийсэн хувьсгал шинэчлэлийн төлөөх нийгмийн хувьсгал хоёр ялгаатай гэдгийг сануулаад уялдааг нь зарим нэгэн баримтаар гаргасан.

Дуртгалаа бичсэн 203 партизануудын дотроос зөвхөн найман хүн 1921 онд намд элссэн бөгөөд 4 хүн 1922 онд элсчээ. Дараагаар таван хүн, тэдний нэг нь бүр сүүлд 1940 онд, элссэнийг тооцох юм бол 1921 оны шуурган жилийн журмын нөхдөөс дөнгөж 17 хүн намын гишүүн ажээ. Эдгээр **шигшмэл нөхдөөс тун цөөхөн нь сүүлдээ өндөр албан тушаалд хүрсэн явдал ийм тооны учрыг бүр тодотгож өгч байна.** Монголын хувьсгал анхнаасаа коммунист зохион байгуулалтын зарчмаар явагдсаныг жирийн партизануудын дуртгал харуулж байна. Түүний цөмийг мэргэжлийн хувьсгалчид бүрдүүлж байсан бөгөөд тэд зөв улс төрийн байр суурь үгүй бол зоригтой эх оронч цэргүүдийг хүртэл намд элсүүлэн авдаггүй байжээ. (О.Латтимор, Нүүдэлчид ба хувьсгалчид, 1994)

Түрэмгийлэгчдийн эсрэг дайн ялсны дараа цэргүүдээс намд элсэж нийгмийн хувьсгалыг гардсан хүний тоо цөөхөн байгааг дурдаад ер нь партизанууд хувьсгалчидтай олон зүйлээр ижил биш байгааг нотолсон. Улмаар тэрээр дурдсан үндэслэл дээрээ тулгуурлан

Эдгээр баримт сэлт нь монголчууд өөрсдөө бүгдийг санаачилсан гэдэг монголын үзэл бодлыг тодорхой болгож өгдөг(О.Латтимор, Нүүдэлчид ба хувьсгалчид, 1994)

гэсэн ерөнхий дүгнэлт хийжээ.

1969 онд “Ардын журамт цэргийн дурдатгалууд” бүтээлийн дэд ботид 282 партизаны дуртгалыг нэгтгэн Л.Дүгэрсүрэн, Г.Цэрэндорж нар боловсруулж Д.Гонгор, Н.Ишжамц нар найруулан гаргажээ. Оршилд нь партизануудыг анги нийгмийн бүрэлдхүүн, хувьсгалд оролцсон шалтгаан, албан тушаал, цэргийн алба хаасан эсэх, нас зэрэг 10 орчим үзүүлэлтээр 50 орчим шкалтайгаар тоолж зарим нэг дүнг гаргажээ. Шинэлэг гэж хэлж болохуйц зүйл бол журамт цэргийн бүрэлдхүүн, анги нийгмийн байдал, тэдний хувьсгалд оролцсон шалтгааныг нарийвчлан судлахын чухлыг зааж өмнөх хэвлэлтэнд хэрэглэж байсан жирийн малчин, хэрмэл цагаачин гэсэн ойлголтыг жинхэн ядуу малчин ард гэж нэрлэсэн нь ангич шинж чанарыг товойлгож эхэлснийг гэрчилнэ. Улмаар эл зорилгод чиглэсэн ангиллыг ч хийсэн.

...элссэн хүмүүсийн олонхи нь жинхэн ядуу малчин ард байсан ажээ. Жишээ нь дурдатгалд орсон 282 хүний 247 нь ядуу зүдүү амьдралын замыг туулж явжээ. Ардын журамт цэрэг үндсэндээ **ард ангийн ядуу, дунд хэсгээс бүрэлдсэн байна. ...занги, залан, мэйрэн, захирагч** гэх мэт тушаалтай түшмэд нилээд байх боловч гол төлөв бичиг цэргийн гавьяа байгуулах замаар уг зэрэг

тушаалыг хүртсэн **ард ангийн гаралтай хүмүүс** байжээ. ...бас ард гаралтай цөөн тооны ядуу, дунд лам, ганц хоёр хохь тайж байжээ. (Ардын журамт цэргийн дурдатгалууд, 1969)

Энд өмнөх хэвлэлтийн зарим нэгэн дүгнэлт тухайлбал нийгмийн бүхий л давхраа оролцсон гэснээс буцаж оролцсон түшмэдийг ч ард гаралтай байсан гэж тайлбарласан. Энэ нь үзэл суртлын хүлээс чангарч, шинжлэх ухаанд гүнзгий нөлөө үзүүлсэнтэй холбоотой. Өмнө дурдаагүй санаа нь журамт цэргийн бүрэлдхүүнд Богд хааны цэргүүд нилээд байсныг дурджээ.

...нэлээд хэсэг нь **хуучин Богд Хаант Улсын цэргийн албыг** аль нэгэн хэмжээгээр хааж байсан хүмүүс буюу орон нутагт ан гөрөө хийж явсан хүмүүс байна. Нилээд нь 1912 онд Ховд хязгаарыг чөлөөлөхөд болон зүүн өмнө хязгаарт хятадын хар цэрэг, бусад түрэмгийлэгчидтэй удаа дараа байлдаж явсан, Хужирбуланд цэргийн сургууль хийж Монгол улсын тусгаар тогтнолын төлөө харийн дайсантай тэмцэж явсан хүмүүс байжээ. (Ардын журамт цэргийн дурдатгалууд, 1969)

Энэ бол 1921 оны хувьсгал 1911 оны хувьсгалын үргэлжлэл гэсэн санааг цаагуураа дурдсан хэрэг. Мөн журамт цэрэгт гурван хэлбэрээр элссэн гэж үзэж, ихэнхи нь сайн дураараа элссэн гэдгийг онцолсон.

...ихэнхи хэсэг нь гэмин, цагааны харгислал, түрэмгийллийг жигшин эсэргүүцэж эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэхээр морио унаж, зэвсгээ зүүж **өөрсдийн сайн дураар элссэн** байна. Нөгөө нэг хэсэг нь **цагааны цэрэгт төөрөлдөж, хүчинд автагдан** яваад тэднээс зайлан зугтаж анги, хороо, хэсэг бүлгээр ардын журамт цэрэгт ирж нийлсэн хүмүүс ажээ. Мөн гурав дахь нь Ардын Түр засгийн газар, түүний төлөөний сайдаас **цэрэг элсүүлэхэд оролцсон хүмүүс** байна. (Ардын журамт цэргийн дурдатгалууд, 1969)

Мөн журамт цэргийн насыг нарийвчлан гаргаж идэр залуу хүмүүс давамгайлсныг тооцсон.

...219 хүний 2 нь 1860 оноос 1870 оны хооронд төрсөн, 17 нь 1871-1880 онд, 46 нь 1881-1890 онд, 124 нь 1891-1900, 40 нь 1901-1907 оны үед төрсөн байна. Үүнээс үзэхэд тэдний 164 буюу 70 хувь нь 19-30 насны идэр залуус байжээ. 30-40 насны амьдралын туршлагатай, хатуужил суусан хашир хүмүүс 63 байжээ. (Ардын журамт цэргийн дурдатгалууд, 1969)

Хамгийн гол нь ард нийтийн хөдөлгөөн нь жам ёсных байсан буюу монголын өнцөг булан болгонд өөрсдийн нь санаачилгаар өрнөсөн гэсэн өмнөх дүгнэлтээ бататгасан.

...ардын хувьсгалыг мандуулж ялалтанд хүргэх их тэмцэл ард нийтийн хөдөлгөөн болж манай орны **өнцөг булан болгонд өрнөсөн** болохыг тодорхой харуулж байна. Ардын журамт цэргийн бүрэлдхүүнийг ажиглавал тэр үеийн халх дөрвөн аймаг, шавь таван газар болон Ховд хязгаар, Дариганга, Хөвсгөлийн урианхай зэрэг бүх Ар монголыг хамарсны дотор Түшээт хан, Сэцэн хан аймгийн хойт зүгийн хошууд, Засагт хан **аймгийн бүх хошуудаас** олонхи нь элсчээ. (Ардын журамт цэргийн дурдатгалууд, 1969)

Дээр дурдсан ажлуудаас гадна нэрт түүхч Б.Ширэндэвийн судалгааны ажлыг заавал дурдах учиртай. Тэрээр хувьсгалын хөдөлгөгч хүч, МАЖЦ-ийн нийгмийн бүрэлдхүүний талаар 38 хүний дурсамж дээр үндэслэн дүгнэлт хийжээ.

1921 оны хувьсгалд оролцсон хүмүүсээс 1956 онд бидэнд товч мэдээ ирүүлсэн хүмүүсийн 38 нь Хиагтыг чөлөөлөх дайнд оролцсон байлаа. Тэдгээр **38 хүн нь монголын 20 хошууны харъяат ардууд байсан** тул монголын **бүх хошуудын бараг зургааны нэгийн төлөөлөгчид Хиагтыг чөлөөлөх тулалдаанд оролцсон гэж болох юм.** ...партизан ...нарын дурсан бичсэнээр ардууд партизан цэрэгт тусламж дэмждэг үзүүлэх явдал газар сайгүй болж тэр нь үнэндээ бүх **ард нийтийн хөдөлгөөний шинжийг** хадгалж байжээ.

Цааш тэрээр 38 хүнийхээ нийгэм ангийн бүтцийг тодорхойлж хувьсгалын хөдлөх хүч нь ард түмэн гээд хамгийн идэвхтэй хэсэг нь ядуу зарц ардууд байсныг тэмдэглэсэн.

Дээр дурдсан 38 хүний 25 нь албат, 6 нь хамжлага, 7 нь шавь байжээ. Тэдгээр нь хөрөнгө чинээний хувьд **их төлөв ядуу, зарц нар** байсан ажээ. Бүрэн биш ч гэсэн нэгэн гол тулалдааны энэ баримтаас авч үзэхэд **ардын хувьсгалын хөдлөх хүч нь ард түмэн, ялангуяа түүний хамгийн идэвхтэй хэсэг нь ядуу зарц ардууд** байсан нь тодорхой байна. Ер нь ардын зэвсэгт тэмцлийн тэргүүн эгнээнд албат, хамжлага, шавийн ядуу зарц хүмүүс голлон явж байжээ. (Б.Ширэндэв, 1999)

Хэдийгээр дээрх баримт нь бүрэн бус хэдий ч нэлээд голчтой дүгнэлт юм. Нөгөө талаас Б.Ширэндэв авхай түүхийн үйл явцыг хувь хүний амьдралын нэг хэсэг болгон задлан харуулж, оролцогч хүмүүсийн намтар дурсамж дээр тулгуурлан тоо баримт нотолгоотой дүгнэлтийг хийснээрээ онцлог юм. Энэ тухай түүхч Л.Бат-очир үүнийг өндрөөр үнэлж ийнхүү бичжээ.

Ширэндэвийн бүтээлийн МАЖЦ-ийн түүхэнд холбогдох хэсгийн нэг чухал ололт бол Ардын журамт цэргийн дайчин явсан **хувь хүний дуртгалыг зохиолдоо эрдэм шинжилгээний үүднээс боловсруулан** ашиглахыг анх тэргүүн оролдсон явдал мөн. Энд хэдийгээр олон хүний дурсамжийг хамраагүй боловч цөөн гэлтгүй ашигласан материалаас хэд хэдэн чухал дүгнэлт хийж чадсан байна. Жишээ нь, Хиагтыг чөлөөлөхөд оролцсон 38 хүний дурсамжаас үндэслэн МАЖЦ-ийн нийгмийн бүрэлдхүүнийг тодорхойлох хийжээ гэжээ. (Л.Бат-Очир, 1999)

Хэрвээ О.Латтимор гуайн судалгааг эс тооцвол анх удаа гэдэг нь зөв юм. Дээрх бүтээлүүдийн дараа 1982, 1985, 1986 онуудад өмнөх ажлаа нэгтгэж "Монгол ардын журамт цэргийн дуртгалууд" бүтээлийг 3 ботиор Түүхийн хүрээлэнгийн С.Уртнасан, Г.Цэрэндорж, Ш.Нацагдорж нар бэлтгэж шинэчлэж хэвлэжээ. Ер нь эл бүтээлүүд нь аугаа их хөдөлмөрийн үр дүн бөгөөд архивийн баримт, амьд эх сурвалж, уйгагүй эрэл хайгуулын үрээр судалгаа шинжилгээний асар их материалыг олны хүртээл болгосон гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Эл бүтээлийн эхний ботийн оршилд өмнөх хэвлэлтийн дүгнэлтийг баталж монголын ихэнхи газраас журамт цэрэгт хүмүүс элссэн гэдгийг дурджээ.

Дуртгалаас үндэслэн ардын журамт цэргийн бүрэлдхүүнийг ажиглавал тэр үеийн Халх дөрвөн аймаг, шавь таван газар, Ховд, хязгаар, Даринганги, Хөвсгөлийн урианхай зэрэг **бүх Ар монголыг хамарсны дотор** Түшээт хан, Сэцэн хан аймгийн хойд хошууд, **Засагт хан аймгийн олонхи хошуунаас** элссэн хүмүүс байна. (Ардын журамт цэргийн дуртгалууд, 1982)

Харьцуулбал 1969 оны хэвлэлд Засагт хан аймгийн бүх хошуунаас гэсэн байсныг 1982 оны хэвлэлд Засагт хан аймгийн олонхи хошуунаас гэж засварласан. Насны хувьд хөгшин ба залуу гэж ерөнхий ангилсан.

Насны ялгаврын хувьд бол барагцаалсан тооцооноос үзэхэд төрсөн он нь мэдэгдэж байгаа бүртгэгдсэн бүх хүний дотроос **70-аад хувь нь 1891-1907 оны хооронд төрсөн 19-30 насны идэр залуус** бөгөөд мөн 1871-1900 оны хооронд төрсөн амьдралын туршлагатай хүмүүс нэлээд хувийг эзэлж байна. (Ардын журамт цэргийн дуртгалууд, 1982)

Нийгмийн давхраажлын хувьд 1969 оны хэвлэлийн байр суурийг өөрчилсөнгүй ангич агуулгыг төвийлгөсөн, бүхий л бүлгүүд хувьсгалд оролцсон гээд нарийн тооцоог хэлээгүй боловч ерөнхийд нь дурджээ.

Тэдгээрийн **олонхи нь ард ангийн ядуу, дунд хэсгээс гаралтай** бөгөөд тэдний дунд занги, залан, мэйрэн, захирагч зэрэг тушаалтай түшмэд нэлээд байх боловч гол төлөв бичиг, цэргийн алба эрхлэх замаар уг зэрэг тушаалыг хүртсэн

ард ангийн гаралтай хүмүүс юм. Ардын журамт цэргийн эгнээнд мөн ард гаралтай цөөн тооны ядуу дунд лам, ядуу хохь тайж байсан байна. (Ардын журамт цэргийн дуртгалууд, 1982)

Өмнө цэрэгт байсан хүмүүсийг онцлон харуулсан өмнөх дүгнэлтийг давтжээ.

Ардын журамт цэргийн зарим нь Богд хаант Монгол улсын үед цэргийн албыг нэлээд хугацаагаар хааж байсны дээр мөн орон нутгийн сайн анчин гөрөөчин хүмүүс байна. Нэлээд нь нь 1912 онд Ховд хязгаарыг чөлөөлөх, Зүүн өмнөд хязгаарт хятадын хар цэрэг, бусад түрэмгийлэгчидтэй улаа дараа тулалдаж явсан буюу Хужирбуланд цэргийн сургууль хийж Монгол эх орныхоо тусгаар тогтнолын төлөө харийн дайсантай тэмцэж хал үзэж хашир суусан хүмүүс юм. (Ардын журамт цэргийн дуртгалууд, 1982)

Мөн журамт цэрэгт элссэн хэлбэрийг гурван үндсэн бүлэгт ангилсан боловч нарийн тооцоог хийгээгүй учир өмнөх дүгнэлтээс ахисангүй.

Ардын журамт цэрэгт элссэн хүмүүсийн олонхи нь гэмин цагаантны харгислал, түрэмгийллийг жигшин эсэргүүцэж эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэлд хүчин зүтгэхээр хувийн морио унаж, зэвсгээ зүүж сайн дураараа ирсэн бөгөөд зарим хэсэг нь тухайн үед хүчинд автагдан цагааны цэрэгт дайчлагдан явж байгаад хожим учрыг ойлгосны үндсэн дээр тэднээс зайлан салж анги, хороо, хэсэг бүлгээрээ журамт цэрэгтэй нийлсэн байна. Мөн ардын түр засгийн газар, түүний төлөөний сайдуудаас цэрэг дайчлан элсүүлэхэд журамт цэрэгт орсон хүмүүс нэлээд бий юм. (Ардын журамт цэргийн дуртгалууд, 1982)

Харьцуулалтаас үзэхэд 1982 оны ба 1969 оны хэвлэлийн дүгнэлт бараг ижил байна.

Дараагийн шатанд түүхч Н.Хишигт партизануудын дуртгалыг нэгтгэн судлах ажлыг гүнзгийрүүлжээ. Тэрээр 1982-1985 онд гарсан гурван боть номон дээр тулгуурлан 969 хүний дурдатгалд судалгаа хийжээ. Түүврийн хэмжээг ихэсгэж анх удаа бүрэн хэмжээний материал ашигласан, мөн дан тоололтыг ч гэсэн чамбай хийж асар их мэдээллийг боломжийн хэрээр нэгтгэн дүгнэсэн, тэр хэрээрээ нарийвчлалтай шинжилгээг хийж олон тоог шинэчилж чаджээ. Үүнд нас, нутаг ус, нийгэм ангийн бүрэлдхүүн, яс үндэс, харьяалал, элсэн орсон хэлбэр, өмнө цэрэгт алба хаасан эсэх зэрэг 10 гаруй үзүүлэлтээр судалжээ. Судалгааны үр дүнгийн эхний хэсэг монголч эрдэмтдийн хурал 5-р их хурал дээр (Н.Хишигт, Ардын журамт цэргийн дурдатгалууд бол хувьсгалын түүх судлалын чухал эх сурвалжийн нэг мөн, 1992) арай дэлгэрэнгүй байдлаар бие даасан бүтээлдээ оруулжээ (Н.Хишигт, 1921 оны ардын хувьсгал ба ардын журамт цэрэг, 2001). Тэрээр журамт цэргийн нийгмийн бүрэлдхүүн, харьяалал зэргийг судалжээ.

Журамт цэргийн нийгмийн бүрэлдэхүүн, засаг захиргааны харьяаллаар Монгол орон, монголын нийгмийг бүрэн төлөөлж чадаж байв. МАЖЦ-ээс "Ардын хувьсгалын партизан" цол хүртсэн Монгол улсын харьяат 960 хүний намтрын судалгаанд үндэслэн журамт цэргийн нийгэм ангийн бүрэлдэхүүнийг авч үзвэл: **73.3 хувь нь ард ангиас гаралтай** хэмээн бүртгэгдсэн байх бөгөөд 3.16 хувь нь лам хувраг, мөн 3 гаруй хувь нь залан занги, түшмэд, ноёд зэрэг дунд, дээд давхрааныхан, үлдсэн хувь нь нийгмийн гарал тодорхойгүй хүмүүс байна. (Н.Хишигт, 1921 оны ардын хувьсгал ба ардын журамт цэрэг, 2001)

Мөн үндэс угсаагаар ялган судалж олон ястан үндэстний төлөөлөгчид оролцсоныг дурджээ.

Засаг захиргааны харьяаллаар журамт цэрэгт элсэгчид нь Халх 4 аймаг, Шавь 5 газар, Ховдын хязгаар, Хөвсгөлийн дархад, Дарьганга, Дөрвөдийн аймаг, казакийн хошууд зэрэг бүх Монгол нутгийг хамарч байсан нь **халх, буриад, цахар, дөрвөд, баяд, казак, урианхай, дархад** зэрэг олон ястан үндэстний төлөөлөгчид үндэс угсаагаа хамгаалан, эх орноо чөлөөлөх тэмцлийн гол хүч

болж байсныг илтгэнэ. (Н.Хишигт, 1921 оны ардын хувьсгал ба ардын журамт цэрэг, 2001)

Журамт цэрэгт элсэгчдийг сайн дураараа ирсэн хэсэг, дайчлагдсан хэсэг, мөн хятадын цэргийн эсрэг тулалдаж байсан хүмүүс гэж гурав ангилжээ.

...тэмцэлд оролцогсдын **57.5 хувийг хувийн уналга морь, зэр зэвсэгтэйгээ сайн дураар элсэгчид, 21.7 хувийг хошуу нутгаас дайчлагсад** тус тус эзэлж байсны хамт хаант Монгол улсын үед хятадын цэргийн эсрэг удаа дараа тулалдаж явсан **дайчин эрс, хуучин цэргүүд нийт бие бүрэлдэхүүний 1/5 орчим** байв. (Н.Хишигт, 1921 оны ардын хувьсгал ба ардын журамт цэрэг, 2001)

Зөвхөн насны хувьд 17-30 насны хүмүүс 70 хувийг эзэлж байсан гэсэн тооцоог шинэчилж 21-40 насныхан 71.2 хувийг эзэлж байгаа гэж үзсэн. Боловсролтой гэж тэмдэглэгдсэн хүмүүсийн тоог нарийн гаргаагүй ч цөөнгүй гэдгийг дурдсан. Байлдсан хүмүүсийг арын албаны хүмүүсээс ялгасан.

...яам тамгын газрын түшмэл, бичээч, хэлмэрч, эх зохиогч зэрэг алба хашиж явсан, бичгийн боловсролтой хэмээн тэмдэглэгдсэн хүмүүс цөөнгүй бөгөөд насны хувьд 15-60 гаруй насныхан байснаас гол цөм нь **21-40 насны (71.3 хувь Н.Х) идэрчүүд** болно. Нийт бие бүрэлдэхүүний 84 хувь нь харийн эзэрхэгчүүдийн эсрэг зэвсэг барин тулалдаж, олон арван цэрэг эрс арын албанд зүтгэжээ. (Н.Хишигт, 1921 оны ардын хувьсгал ба ардын журамт цэрэг, 2001)

Дээрх судалгааны баримт дээр тулгуурлан тэрээр дараах дүгнэлтийг хийжээ.

XX зууны Монгол нийгэм ангийн бүрэлдэхүүний тод тусгал болсон эл байдал нь 1921 оны хувьсгалын үндсэн зорилт ба түүнийг хэрэгжүүлсэн арга зам нь **нийгмийн янз бүрийн анги давхрааны эрх ашигт нийцэж байсныг** давхар гэрчилнэ. (Н.Хишигт, 1921 оны ардын хувьсгал ба ардын журамт цэрэг, 2001)

Н.Хишигтийн судалгаа нь нэлээд нарийвчлал сайтай бөгөөд гаргасан дүгнэлт нь ч гэсэн шинэлэг юм. Гэхдээ түүнд мэдээллээ боловсруулж бүрэн дүүрэн ашиглах тал дээр бусад судлаачдын адил төвөг учирч байсан болов уу. Лавтайяа партизануудын дуртгал дээр ажилласан хүмүүсийн судалгаанаас тоймлоход ийм байна. Үүнээс гадна өөр олон түүхчдийн дүгнэлт бий. Тухайлбал түүхч Л.Бат-Очир энэ тухай хоёр санал дэвшүүлсэн.

Үнэндээ бол МАЖЦ-ийн **олонх нь Богд хаант улсын үед Хужирбулан зэрэг газар цэргийн алба хааж** зүүн өмнөд хязгаарт улсын тусгаар тогтнолыг хамгаалан хятадын хар цэргийн эсрэг тэмцэгчид хятадын дарлалыг эсэргүүцэн босож **Монголд дагаар орсон Тогтох тайж, Сумьяа бэйс нарын харъяаны хүмүүс**, Умар хязгаарыг сахин хамгаалах **харуулын ардууд** зэрэг цэрэг байлдааны зохих туршлагатай хүмүүсээс бүрэлдэж байснаас гадна МАЖЦ-ийн удирдах хэсэг нь голцуу МАН-ын гишүүд байсан ч бие бүрэлдэхүүний ихэнх нь **намын гишүүн бус эх орончид** байсан юм. (Л.Бат-Очир, 1999)

Тэрээр Тогтох тайж, Сумьяа бэйс нарыг тусгайлан нэг бүрэлдхүүн болгон үзсэн нь шинэлэг бөгөөд бие бүрэлдхүүний ихэнх нь намын гишүүн бус эх орончид байсан хэмээн О.Латиморын дүгнэлтэнд ойртжээ. Мөн зарим судлаач шуудхан

1921 оны ардын хувьсгалд оролцогчдын дийлэнхи хувь нь Хужирбулангийн цэрэгт алба хаагчид эзэлж байв. (Б.Даваасүрэн, 1999)

гэсэн нь ч бий. Түүхч Д.Гонгор, Л.Дүгэрсүрэн, Г.Цэрэндорж, О.Латтимор, С.Уртнасан, Н.Хишигт нарын дээрх судалгаанууд нь асуудлыг тодорхойлж, нарийвчилж, судалгааны ерөнхий таамаглалыг шалгах, мэдээлэл боловсруулах шинжилгээ хийх загвар гаргахад их тус болсон. Манай судалгаа сүүлчийн гурван боть дээр тулгуурласан боловч өөр хооронд нь харьцуулж үзэхүл нэлээд ялгаа бий. Тухайлбал сүүлчийн хэвлэл нь эхний хэвлэлтэй харьцуулахад зарим тохиолдолд бага сага материалыг хассан байдал гарчээ. Тиймээс энэ судалгаагаа хийхдээ шинэ ба хуучин хэвлэлийг тус бүрд нь тулгаж

аль болох дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хичээсэн.

1982-1986 оны гурван ботиос түүвэрлэн авсан 927 хүний намтар, дуртгалд судалгаа хийв. Ингэхдээ бидний сонгон авсан үндсэн үзүүлэлт, шкалд шаардлагатай мэдээлэл 50 хувиас бага байвал хассан болно. Шаардлага хангасан мэдээлэлтэй хүмүүсийн товч намтар, дурдатгалыг нэгтгэн мэдээллийг 55 үзүүлэлтээр 300 орчим шкалаар задлаж улмаар нэгтгэсэн. Мэдээллийг задлах, ангилж бүлэглэх, хэрэглэгдхүүн болгож боловсруулах, шивэх, улмаар нэгтгэх, математик статистик боловсруулалт хийх ажил тун ч нарийн төвөгтэй байсан гэдгийг хэлэх хэрэгтэй.

	Хэддүгээр боть	Нийт дурдатгалын тоо		Судалгаанд хамарсан дурдатгалын тоо	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1	0			2	.2
2	1-р боть	320	34	307	33.1
3	2-р боть	353	37.5	350	37.7
4	3-р боть	267	28.5	267	28.9
5	Total	940	100	927	99.9

Хүснэгтэнд нэгдүгээр ботиос бид 307 хүний намтрыг, хоёрдугаар ботиос бид 350 хүний намтрыг, гуравдугаар ботиос бид 268 хүний намтрыг нийтдээ 927 хүнийг судалгааны ажилдаа хамруулсан болно.

Хоёр. Хувьсгалчдын гараа ба социал дүр төрх

1. **Хувьсгалчдын гэр бүлийн байдал.** Үндэсний ардчилсан хувьсгалд оролцогчдын тухай өгүүлэхэд тэдний өрх, гэр бүлийн байдал чухал юм. Нэрт социологич О.Конт гэр бүлийг нийгмийн тогтвортой байдлыг хангагч институт гэж тодорхойлсон (О.Мөнхбат, 2002). Гэр бүлээс хүн уламжлал, ёс заншил зэргийг суралцдаг бөгөөд нийгмийн анхдагч бичил орчин учир гэр бүл хэдийчинээ тогтвортой байна, нийгэм төдийчинээ статик байдлаа хадгалдаг гэж үзсэн. Судалгаагаар 384 хүн журамт цэрэгт элсэхийн өмнө аав ээжтэйгээ хамт амьдардаг байсан бол үлдсэн 338 хүний өрх, гэр бүлийн талаархи мэдээлэл олдоогүй болно. Эцгийн гэрээс цэрэгт мордсон нэгэн хүний жишээг сонирхоё.

1921 оны намар би 24 настай байжээ. Цэрэг дайчлагын зар дуудлага ирэв. Хэрхэхийг эс тулгуурлан учир эцгээсээ лавлав. Аавын бийд хүнтэй танилц. Агтны бийд газар үз гэсэн үг бий. Аавынхаа танаг тэнхээтэйд юм үзэж, нүд тайлж авдаг нь зөвдөнө гэж хэлээд намайг цэрэгт мордуулж билээ. (Я.Дэндэв, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985).

Мэдээлэл олдсон хүмүүсийн 65 хувь нь аав ээжтэйгээ амьдардаг, 34.8 хувь нь өрх тусгаарласан, мөн өнчин өрөөсөн хүмүүс байна.

	Ааж ээжтэйгээ амьдардаг	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	0	338	36.4	0	0
2	Тийм	384	41.4	384	65.2
3	Үгүй	205	22.1	205	34.8
4	Нийт	927	99.9	589	100

Мөн нөгөө талаас журамт цэрэгт элсэхийн өмнө өрх тусгаарласан байсан эсэхийг солбиж судласан юм. Нийтдээ 483 хүнээс энэ тухай мэдээлэл цуглуулсан боловч 26 орчим хувь нь л өрх тусгаарласан хүмүүс байна.

	Өрх тусгаарласан	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	0	444	47.8	0	0
2	Тийм	126	13.6	126	26.3
3	Үгүй	356	38.4	356	73.7
4	Нийт	926	99.8	483	100

Тэр үед түүхч З.Лонжидын судалгаагаар нэг өрхөд дунджаар 4.6 хүн ноогдож байжээ. (З.Лонжид, ХХ зууны эхэн үеийн монголын нийгэм эдийн засгийн төлөв байдал, 1995) Мөн бага балчир насандаа буюу 18 нас хүрэхээс өмнө хагас ба бүтэн өнчин байсан эсэх талаар сонирхон судалсан юм. Алдарт Францын хувьсгалын хөдөлгөгч хүч нь нийгмийн эмзэг хэсэг байсан гэсэн нотолгоог олон эрдэмтэд дэвшүүлдэг. Тэгэхлээр манай хувьсгалд ямар байсан вэ?

		Нийт түүвэр		478 хүнээс		Нийт түүвэр		478 хүнээс	
		Хагас өнчин		Хагас өнчин		Бүтэн өнчин		Бүтэн өнчин	
	Хагас ба бүтэн өнчин эсэх?	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	0	449	48.4	0	0	454	48.9	0	0
2	Тийм	25	2.7	25	5.2	26	2.8	26	5.4
3	Үгүй	453	48.8	453	94.8	447	48.2	447	95.1
4	Total	927	99.9	478	100	927	99.9	473	100

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн бараг тал нь буюу 48.4 хувь нь энэ тухай дурдатгалдаа дурдаагүй. Мэдээ баримт нь олдсон хүмүүсийн хувьд 5.2 хувь нь хагас өнчин, 5.4 хувь нь бүтэн өнчин, нийтдээ 10.6 хувьд хүрч байна. Хариулаагүй хүмүүсийг хариулсан хүмүүстэй ижил тархалттай байгаа гэж тооцвол нийт партизануудын 10 хувь нь өнчин гэж хэлж болно. Эдгээр өнчин гэж хариулсан хүмүүс нь бага насандаа эцэг эхээ алдсан бөгөөд энэ үйл явдал нь журамт цэрэгт элсэхэд чухал нөлөө үзүүлжээ. Өнчин ядруу хүмүүс өөрсдөө сайн дураараа ихэвчлэн цэрэгт явдаг байв.

Бүр нялхад минь эцэг Жамбал, арван хоёр настайд минь эх Чанцал тус тус нас барж хоёр эгчтэйгээ өнчин хоцорчээ. ...улаа нэхдэг ажилтай болоод гэминд морио булаалгаж хорсож яваад өөрөө сайн дураараа журамт цэрэг нийлсэн. (Ардын журамт цэргийн дуртгалууд., 1986)

Мөн харж хандах хүнгүй учир цэрэгт дайчлагдах явдал ч түгээмэл тохиолдоно.

Би бага насандаа эцэг эхээс хагацсан ба 20 наснаас биеэ дааж амьдрал зохиосон боловч хоосон ядуугийн учир, ан гөрөө хийх, бусдад зарцлагдах зэргээр амьдарч явав. 1921 онд айлд зарцлагдаж байтал цэрэгт дайчлан явуулав (Ардын журамт цэргийн дуртгалууд., Ж.Даваацэрэн, 1982).

Ер нь гэр бүлтэй, мал ахуйтай, стандартны амьдралтай хүмүүстэй харьцуулахад гэр бүлгүй, өнчин өрөөсөн хүмүүс нь эрсдэлд их өртдөг, тэр хэрээрээ нийгмийн өөрчлөх үйлсэд бусдаасаа идэвхтэй оролцдог. Дунджаар 10 хүн тутмын нэг нь хэвийн бус гэр бүл юм уу гэр бүлгүй байгаа нь өндөр юм. Түүнчлэн жирийн иргэдийн хувьд цэрэгт явах нь нэг талаас цөллөг, дайчилгаа, нөгөө талаас амь зуух хэлбэр болж байсныг хэлэх хэрэгтэй. Маш олон хүн амь зуух л гэсэн энгийн шалтгаанаар цэргийг сонгож байж.

Ноорхой гэр, навтархай хувцас, арваадхан ямаатай үлдсэн бид нутгийн баян Дэгээхүүгийн адуу малын хариулан зарцлагдаж явлаа. 1921 оны хавар юмсан, Хатанбаатарын захирч байсан монгол цэргийн хүрээний горьтгийг аймшиггүй алхаж гуйлга гуйж очив. Тэгтэл хэн нэгэн нь тэр цэрэгт ор гэхэд ид хорин дөрөвтэй явсан ядуу зүдүү би хоол хувцасны ая харж цэргийн хүн болсон юм. (Г.Цанжид Ардын журамт цэргийн дуртгалууд., 1986)

Нөгөө талаас эцэг эхгүй, айлд зарагдаж амь зуудаг, хэлж зөвлөх, харж хандах хүнгүй, баян айлын хүүгийн оронд цэргийн алба дүйсэн, санаандгүй явж байгаад элсчихсэн, тэртээ тэргүй татлаа түтлээ байхгүй, мөн хэл ам хийж

чаддаггүй чих зөөлөн учир эмзэг бүлгээс голдуу гаралтай хүмүүсээс үндэсний армийг бүрэлдүүлж байж. Гайхалтай нь эндээс хувьсгалын гол хүч, нийгмийг өөрчлөгчид төрөн гарсан. Нэг үгээр хэлбэл эрсдэлд орохоос буцахгүй, тийм хүмүүсээс бүрдсэн армийг цаг үе нь өөрөө бэлдэж байж, тэд хувьсгалын хатуу хүтүүг үүрсэн. Дэлхийн олон оронд болсон хувьсгалд люмпень пролетари гэж Марксын нэрлэсэн хүмүүс тодорхой үүргийг гүйцэтгэсэн бөгөөд тэд оролцсон ч үгүй ч тэртээ тэргүй муу амьдралаа сайжруулахад тун төвөгтэй, байгаа амьдрал нь өөрөө эрсдэл болчихсон, гинжнээсээ өөр алдах юмгүй хүмүүс юм. Тиймээс францын, оросын, хятадын үе үеийн хувьсгалд маргинал бүлэг багагүй үүрэг гүйцэтгэсэн. Дайн гэдэг хамгийн өндөр эрсдэлтэй зүйл, тиймээс олон хүмүүс болгоомжилж байв. Үнэхээр ч стандартны амьдралтай, өөрийн гэсэн мал хөрөнгөтэй, гэр бүл, үр хүүхэд, аав ээжтэйгээ, айл хотлоороо амьдарч байсан хүмүүс хувьсгал, дайн тулаан зэрэг эрсдэлтэй үйлсэд оролцохдоо хойрго байдаг.

Баян айл хүүхдээ цэрэгт явуулдаггүй чөлөөлж авдаг байсан жишээ цөөнгүй байна.

1921 оны хавран адаг, зуны эхэн сард хошуу нутгаас цэрэг татаж байх үед нэг баян хүн өөрийн хүүг цэрэгт явуулах дургүй байсан учир түүний хүүгийн оронд би явах болж харин тэр баян айл манай гэрт тугалтай хоёр үнээ өгөхөөр тохирсон юм (С.Дамдинбазар, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1982).

Гэхдээ тэд эх орондоо хайргүйдээ биш зүгээр л итгэхгүйдээ, болгоомжилсондоо хойш сууж байсан. Тийм учраас хувьсгалчид олон хүнийг хүчээр цэрэгт татаж байв.

1921 оны зун манай отгийн даргаас миний биеийг Улиастайд мордуулах цэрэгт хөөж ирэв. Тэр үед эхнэр жирэмсэн гачигдалтай байгаа учрыг отгийн даргад гаргавч огт хэрэгсэхгүй шууд хөөн мордуулж Бирваа бэйсийн хошууны тамгын газар ирэв. Хэд хоносны дараа Хатанбаатар Магсаржавын цэргийн ангид хүргүүлсэн. (Н.Содномдаржаа, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1986)

Үүнийг тайлбарлахад үндэслэл бий. Жишээлбэл эх орноо гамингийн дарлалаас аварна гээд хэн нь ч мэдэгдэхгүй нэг хүн (ядахдаа тэр нь хувилгаан ч биш, язгууртай ноён ч биш, дайны баатар бүр биш) ирээд миний араас гээд байвал эх орондоо их хайртай ч шууд дагахын өмнө олон хүн эргэлзэнэ. Тэрчлэн мэдээлэл муутай зах хязгаар нутагт янз бүрийн шалтгаан хэлж цэрэг татахыг шаардсан зүсэн бүрийн хүмүүс очсоор үнэндээ залхаагаад байв. Ийм шалтгааны улмаас Дүрвэдийн зүүн аймгийн Дүрвэд далай хааны хошуунд Дамбадоржийн цэрэг татах ажил орон нутгийн үл дэмжлэгтэйгээр бараг зогссон жишээ ч бий.

Дагдан захирагч биднийг маш ширүүнээр харж "Та нарыг цэрэгт хэн оруулж нэрийг чинь бичүүлэв" гэж асуухад, бид нэрээ бичүүлсэн учраа хэлэв. Дагдан захирагч тун их уурлаж "Урьд хоёр тэмээт гэдэг хүн ирж үймүүлж байсан, одоо Хасбаатар, гэгч бадарчин ирж дур мэдэн цэрэг элсүүлэхэд та нар нэрээ бичүүлж байна. Та нарыг бид мэднэ. Дараа шийтгэнэ" гэж загнав. (Н.Жамхүү, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1985)

Нөгөө талаас ийм цөөхүүлээ шороон түмэн хятадыг дийлэх үү? Тэртээ тэргүй тусгаар тогтнолоо алдчихсан биз дээ, би гачигдалтай учир чадахгүй гэх мэт өөрсдийгөө зөвтгөх шалтаг мундахгүй юм. Нүүдэлчдийн тухай Д.Г.Гумилёв өөрийн бүтээлдээ

Нэг нь үхээ л биз, би үхээгүйгээс хойш боллоо. Тэр байлдаад, амиа алдаад, сайн юм юу ч болоогүй. Би одоо очиж үнээгээ саагаад сүүгээр нь архи нэрээд ууя. Хонь муулаад сайн хоол идэж авъя. Нар мандаж байна, ногоо ургаж байна, мал биэлчиж байна, юугаа бодох вэ? (Д.Г.Гумилёв, 1995)

гэж тулга тойрсон л юм боддог гэж дүрсэлсэн байдаг. Үүнийг бага зэрэг хэтрүүлэгтэй ч үнэний ор бий юм. Тиймээс чинээлэг голдуу айл хүүхдээ цэрэгт явуулснаас ацагласан нь дээр гэж үзэж байв. Анхны партизануудын дотор тамгын газар хүний оронд дайчилсан, тодорхой хөлс авч баян айлын хүүхдийн оронд явсан жишээ цөөнгүй бий. Ингэснээр жирийн монголчууд эх орныхоо төлөө сайн дураараа байлдсан түүхийг үгүйсгэх гэсэнгүй харин олон баримтыг зөвхөн сайхан талаас нь нэг утгатайгаар тайлбарлах нь учир дутагдалтай юм.

Гэвч цаг хуучин шигээ биш болжээ, үүнийг монголчуудын дийлэнхи нь ойлгоод тэр ч байтугай эрвийх дэрвийхээрээ хөдөлж эхлэлээ. Монголын нийгэмд асар том реформ хэрэгтэй гэдгийг жирийн хүн ч ч мэдрэх болж монгол орон асар том эргэлт хийхэд аль хэдийн бэлтгэгдсэн байв.

2. Хувьсгалын өмнө тэд ямар ажил эрхэлж байсан вэ?

Хувьсгалчдын өрхийн орлогын эх сурвалж, эрхэлж байсан ажил хөдөлмөрийг нарийвчлан судлах оролдлогыг бид хийсэн ч мэдээлэл хангалттай биш байсан гэдгийг хэлэх хэрэгтэй. Юуны өмнө цэрэгт явахын өмнөх орлогын эх сурвалж нь ямар байсан талаар 31.7 хувь нь буюу 294 хүний мэдээлэл олдоогүй, үлдсэн 633 хүний баримт дээрээ тулгуурлаж тооцоолов. Монголчуудын хөдөлмөрийг агуулга ба шинжээр нь хэв маягчилж ангилсан. Үүнд оюуны хөдөлмөр эрхлэгчид, малчид, биеийн хүчийг үнэлэгчид, цэргийнхэн гэсэн 4 бүлэг үүсч байна. Мэдээж нүүдлийн мал аж ахуй гол салбар учраас дээрх бүх бүлэг мал аж ахуйтай ямар нэгэн байдлаар холбоотой, гагцхүү дагнан мал малладаг хүмүүсийг нэг бүлэг болгон ялгасан, биеийн хүчийг үнэлэгч хэсэгт бага зэргийн малтай боловч голлон газар тариалан, ан гөрөө хийдэг гэснийг шалгуур болгон авсан болно.

	Ангилал	Үндсэн шинж тэмдгүүд	Тоо	Хувь
1	Оюуны хөдөлмөр эрхлэгч	Цахилгаан мэдээний газар, хэлмэрч орчуулагч, бичгийн алба, лам, түшмэл, бичгийн дарга	37	5.8
2	Малчид	Дан ганц мал малладаг хүмүүс	321	50.07
3	Биеийн хүчийг үнэлэгчид	Чинээлэг айлд зарцлагдах, газар тариалан-мал аж ахуй, мужаан дархан, биеийн хүчийг үнэлэх, ан гөрөө-мал аж ахуй, гуйлга гуйх, гар урлал, өртөө улаа-мал аж ахуй, худалдаа наймаа, мод бэлтгэх, тэнүүчлэх	244	38.5
4	Цэргийнхэн	Богдын бие хамгаалагч, харуул занги, цэргийн алба, чуулган дарга, жанжин	31	4.8
		Нийт	633	100

1.Оюуны хөдөлмөр эрхлэгчид: Энэ бүлэгт бичээч, лам, түшмэл зэрэг оюуны хөдөлмөр эрхэлдэг хүмүүс орсон. Мөн шинэ тутам байгуулагдсан цахилгаан мэдээний газар, сургуулийн багш зэрэг хүмүүс нэмэгдсэн. Орон нутагтаа хошууны тал бичээчээр ажиллаж байсан нэгэн хүний жишээг сонирхоё.

Багадаа орон гэр ядуу учраас нутгийн Соном захирагчийн хонь хариулж хар бор ажил хийж байхдаа Соном захирагчаар монгол бичиг заалгав. Соном захирагчийг дагаж Жалханзын шавийн тамганд тал бичээчийн ажил хийж явав. Тал бичээчийн алба хаахад сардаа төлөг, хугас цай авдаг байв. (Д.Дэндэв, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Дээрхээс харахад оюуны хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн ч гэсэн амьдрал төдийлөн сайнгүй, ялангуяа хувьсгалд ийм хэсэг нь илүүтэй оролцсон байна. Оюуны хөдөлмөр эрхлэгчид ингэж бага гарсан нь лам нартай бас холбоотой.

Хувьсгалчдын хичнээн хувийг лам нар эзэлдэг вэ? гэсэн асуулт зүй ёсоор гарна. Лавтайяа судалгаанд хамрагдсан 928 хүнээс 3.2 хувь нь буюу 30 хүн хийдэд шавилан сууж байжээ.

	Хийдэд байсан	сууж	Тоо	Хувь
1	0		252	27.2
2	Тийм		30	3.2
3	Үгүй		645	69.5
4	Total		927	99.9

Лам нар ганц нэгээрээ ч биш бүлгээрээ элсч байсан баримт олон байна.

Бидний хэдэн лам нар Эрдэнэ вангийн хүрээнд сууж байхад 1921 оны эхээр Базарсад гэдэг хүн очиж дагуулан яваад Орхон-Сэлэнгийн бэлчир Алтан гэдэг газар Сүхбаатарыг байхад уулзуулж түүний цэрэгт оруулав. (Ж.Жадамба, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Мөн өөрийгөө лам байсан гэдгээ шууд дурсах дургүй байгаа нэг хүний дуртгалыг сонирхоё.

Би эцэг эхийн гар дээр хүмүүжиж Улиастайн ногооны хашааны тэрэгний морьд маллах, бусдын тэрэг хийх зэргээр амьдарч байв. Бас лам болж Улаан сүмийн дуганчийн нэр зургаан жил зүүж явлаа. (О.Дулам, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Баримтаас үзэхэд тэрээр өөрийгөө лам байсан гэдгийг ихэд тойруулан хэлсэн байгаа гэдгийг хэлэх хэрэгтэй. Төрсөн оноос тооцвол 28 насандаа журамт цэрэгт элссэн, өмнө 6 жил лам болж Улаан сүмийн дуганч нэр зүүж явж байжээ. Тэгэхлээр энэ хүн амьдралынхаа цөөнгүй хэсгийг сүмд зарцуулжээ. Чухам яагаад лам байснаа хэлэхээс зайлсхийж байна вэ? Тэгэхлээр энэ хүнтэй ижил өөрийгөө лам байсныг нуусан олон хүн бий нь эргэлзээгүй. Үүнийг дуртгал бичиж байх үеийн цаг хугацаа, үзэл сурталтай холбон тайлбарлаж болно. Харин 252 хүн энэ тухай хөндсөнгүй, тэгэхлээр тэдний дотор лам нар нэлээд байсан болов уу. Хувьсгалын үйл ажиллагаанд лам нар хэрхэн оролцсон талаар түүхч З.Лонжид бичихдээ

1921 оны Монголын үндэсний хувьсгалын их үйлсэд лам нар нэн идэвхтэй оролцсон төдийгүй хувьсгалын ялалтын гол түшиг тулгуур болсон Монгол ардын журамт цэргийн анхны дөрвөн хороо цэргийн нэгийнх нь даргаар да лам Хасбаатарыг томилж Хиагтыг чөлөөлөх тулалдаанд оролцуулж байсан нь ч санамсаргүй тохиолдолд огт биш буй за. Өнгөц судалгаагаар бол анхны дөрвөн хороо цэргийн 20 орчим хувь нь хүрээ хийдэд данстай буюу урьд нь хар болсон лам нар байснаас ч үзсэн 1921 оны хувьсгалд лам нар идэвхтэй оролцож томоохон үүрэг гүйцэтгэснийг хэрхэвч үгүйсгэх аргагүй юм. Голлох бүлгийн гишүүдийн нэлээд нь лам нар байв. Жишээлбэл Д.Чагдаржав, Д.Бодоо, С.Данзан, Х.Чойбалсан нар мөн 5-8 жил шавилж байсан лам гэж хэлж болохуйц хүмүүс байв (З.Лонжид, 2002).

гэжээ. Тэгэхлээр бидний баримтыг З.Лонжид гуайн судалгаатай харьцуулж үзэхүл дуртгалд олон хүн лам байснаа нуун дарагдуулжээ. Нэрт монгол судлаач Рупен абугай өөрийн бүтээлдээ Грумм Гржимайлогийн бүтээлээс иш татаж

...лам нарын дийлэнхи нь жирийн хар хүмүүсийн байдлаар амьдарч, тэднээс ганцхан хувцсаараа л ялгарч байсан юм. Лам нар энгийн хар хүмүүстэй хамт хилийн харуулын алба хашиж, тэр ч байтугай эр цэргийн албыг заавал хаах ёстой байжээ. Тэд өөрсдийн ижил бүлгийнхний хамт цэргийн албанд татагдаж, заримдаа нум сумаар мэргэн харвах хичээл заалгадаг байв. (А.Роберт, 2000)

гэжээ. Ямар боловч тоотой хэдэн хүнийг эс тооцвол журамт цэргийг бүрдүүлсэн

цэргийнхэн ба оюуны хөдөлмөр эрхлэгчдийн дотор хуучны язгууртнууд, хутагт хувилгаад бараг оролцоогүй юм. Дийлэнхи нь борчууд, харц ардаас гаралтай хүмүүсээс журамт цэрэг бүрдсэн, үүнд дотроо цэргийнхэн тусгаар тогтнолын төлөөх хувьсгалыг манлайлан явж хийсэн бол оюуны хөдөлмөр эрхлэгчид хувьсгалын дараа засгийн эрхийг барьж нийгмийн хувьсгалыг гүйцээх тавилан тохиожээ.

2. Малчид: Судалгаанаас үзэхэд партизаныудын хувьд цэвэр мал аж ахуй эрхэлж амьдардаг хүмүүс 50.7 хувийг эзэлж байна. Нарийвчилсан судалгаагаар энэ хувь улам өсөх учиртай. Чухамдаа мал маллах ажил мэргэжлээ гэнэт сольж буу зэвсэг барьж явахад ихээхэн зориг шаардсан гэдэг нь тодорхой.

Манайх Матад хан уулаа бараадан нутаглаж хувийн амьжиргааны хэдэн цөөхөн малтай түүнийгээ шүтэн амьдарч байлаа. (У.Жав, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Анчин гөрөөчин биш л бол монголчууд оготны хамраас ч цус гаргахыг нүгэл гэж номлодог шарын шашинд хүчтэй нэвчсэн байсан гэдгийг санах хэрэгтэй. Тиймээс олон хүний хувьд цэрэгт явах нь дассан амьдралаа орвонгоор нь эргүүлж буй хэрэг бөгөөд дайн дуусмагц ихэнхи нь идээшсэн нутаг, сурч дассан ажил руугаа явна гэдэг нь тодорхой юм. Дээрх баримтаас хувьсгалын голлох хүч нь малчид байсан гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

3. Биеийн хүчийг үнэлэгчид: Манай журамт цэргийн бараг 40 хувь нь биеийн хүчийг үнэлэгчид эзэлж байна. Биеийн хүчийг үнэлэгч гэгчид хүний мал хариулах, газар тариалан эрхлэх, өртөө улаа нэхэх, худалдаа наймаа хийх, мөн чинээлэг баян айлд зарагдах зэрэг ажил хийдэг хүмүүсийг оруулав.

18-25 нас хүрэх завсар хувийн бага хөрөнгө мал барагдан хоосорсон учир арга буюу хөгшин эх ба өөрийгөө тэжээхийн тулд бусдад биеийн хүчийг үнэлэн аян жинд явах, бага сага худалдаа арилжаа хийж амь зууж явав. (Т.Ёндон, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Мөн дээр өгүүлснээс гадна ан гөрөө хийх, мужаан дархан хийх, юм үүрэх, мод бэлтгэх, гуйлга гуйх, гар урлал, аж ахуй, худалдаа наймаа, тэнүүчлэх биеийн хүчийг үнэлэх зэрэг ажил ч багтсан.

Би долоон настай байхад эцэг нас барж түүнээс хойш анчин гөрөөчин дагаж 17 нас хүртлээ ангаар хөөцөлдөж явав. (Х.Дэчинлхүндэв, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Ямар боловч эдгээр хүмүүс нь хувьсгалд олноороо оролцож ихээхэн чухал үүрэг гүйцэтгэжээ.

4. Цэргийнхэн: Уламжлалт нийгэмд цэргийнхэн маш өндөр эрх ямба, албан тушаалыг зүй ёсоор эзэлдэг, нэр хүнд ч сайтай байдаг. Гэтэл манжийн ноёрхлын дараах үеийн монголд эсрэгээрээ байв. Бүр Богд хааны үеэс эхлэн цэрэгт явах нь жирийн иргэнд нэр хүнд, эрх ямба, хөрөнгө орлогын алийг ч бий болгож чадахгүй юм. Хэдэн зуун жил үндэсний армигүй байж ирсэн үндэстэн 1911 онд үндэсний тусгаар тогтнолоо олсон ч эдийн засгийн чадавхгүй учраас армид зарцуулах мөнгө байхгүй байв. Төв засгийн газрын хувьд үндэсний армитай болох нь нэгдүгээрт тусгаар тогтнолоо хамгаалах, хоёрдугаарт тодорхой ноёдын салан тусгаарлах оролдлогын эсрэг хамгийн чухал зүйл байв. Тийм ч учраас эл санаачлага эрх мэдлийн төлөөх бүлэглэлүүдээс дэмжлэг авахгүй байх байдлаар илэрч байжээ. Энэ тухай нэрт монгол судлаач Рупен

бичихдээ

Цэрэг татлагыг хариуцдаг хошуу гагцхүү тун тэнцмээргүй, тун хүсүүшгүй харьяат нараа цэрэгт явуулж байсны дээр лам нар өөрсдийнх нь ноёлох байр сууринд аюул учруулж болзошгүй гэж болгоомжлон үндэсний арми байгуулахыг улайран эсэргүүцэж байлаа (А.Роберт, 2000).

Төв засгийн газрын армийн талаархи бодлого нь ийм зөрчилтэй, тууштай биш байдал нь санхүүгийн бэрхшээлтэй хавсран монголын цэргийг үндэсний арми гэж хэлэхэд тун ч хүнд нөхцөл байдлыг үүсгэсэн юм. Тийм ч учраас монголын арми нь хамгийн хоцрогдсон, нэр хүндгүй, мөнгөгүй тэр хэрээр нийгмийн эмзэг бүлгийнхэн, ядуу, өнчин өрөөсөн хүмүүс голдуу дайчлагдаж байжээ.

Дорнодын ...иргэн миний эцэг ...гэр ядуу хогшил нимгэн мал цөөний учир бусдын мал адуулахын зэрэгцээ ан гөрөө эрхлэн аж төрж байжээ. Тэгтэл хөөрхий аав насан өөд болов. Тэгтэл хошууны тахар нэгэн өдөр ...цэргийн албанд мордуулна гэж бачимдуулав. "Тус хошуу нутгаас цэрэгт мордогсодын дотор өнчин ядуу нь ганцхан чиний хүү биш шүү. Дуугаа татаж хүүгээ бушуу явуул" гэж бухимдан тулгав. (Ц.Санжаа, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1985)

Цэргийн хүнд албыг албадан хугацаагүй хашдаг байж. Бүр сүүлд энэ тухай ардын журамт цэрэгт элсэгчид ийнхүү өгүүлж байжээ.

"Урьд бид ээлж дугараагүй, хувцас хунаргүй дарлуулж явлаа. Оргож зугтаж ч явсан. Одоо бол ээлж дугаартай, хувцас хунартай боллоо. Урьд цэрэгт ноёд баядын хүүхэд сугаран хоцорч, бидний ядуу ардын хүүхэд явдаг байсан юм. Одоо бол цэргийн насанд тэнцсэн хэн ч явж болно" гэж хэлэв. (Ц.Санжаа, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1985)

Тийм ч учраас армид хөрөнгө мөнгө амлаж элсүүлэх явдал нэлээд гарч байжээ. Тухайлбал Барон Унгерн монгол цэрэг элсүүлэхдээ олон хүнд алтан монет амласан явдал гарч байсныг хойно өгүүлнэ. Журамт цэргийг элсүүлэхэд ч гэсэн иймэрхүү арга хэрэглэх явдал элбэг биш ч гарч байжээ.

Аавын зааж өгсөн айлуудаар очиж хоргой Шаравын хэлсэн ёсоор "Баян айлын зарц" ядуу хүмүүс цэрэгт элсэж Хиагтыг эзэлж байгаа гэмин цэргүүдийг устгах юм гэнэ. Харин түүнд оролцсон хүмүүс Хиагтын пүүсүүдэд байгаа "булигаар, цай, даалимбуу, торго, чисчүү зэргийг хувааж аваад тарах юм" гэнэ гэж зарлан ухуулж 2-3 хоног яваад 16 хүн элсүүлэв. Миний хэлснийг сонсоод хүмүүс дуртай зөвшөөрч байв (Ардын журамт цэргийн дуртгалууд, С.Ёндонжамц, 1986).

Бүр 1911 оны хувьсгалын үеэр хятадын пүүсийг талах, дээрэмдэх явдал нь монгол орны өнцөг булан бүрд гарч байсантай холбон үзэхүл дээрх баримт магадтай болов уу. Дүгнэвэл нийт партизаныудын тал хувийг малчид, 40 хувийг биеийн хөдөлмөр эрхлэгчид, 5 хувийг оюуны хөдөлмөр эрхлэгчид, мөн 5 хүрэггүй хувийг цэргийнхэн бүрэлдүүлж байсан нь нь бүхэлдээ дунд анги хувьсгалын хөдлөх хүч нь байсан гэдгийг харуулж байна.

3. Хувьсгалчдын социал статус: Хувьсгалчдын хувьсгалд оролцохын өмнөх социал статусыг тодорхойлохын тулд юуны өмнө нийгмийн гарлыг судлах шаардлагатай. Учир нь уламжлалт нийгэмд нийгмийн социал статусыг тодорхойлдог хамгийн гол зүйл бол угсаа гарал байдаг (Х.Гүндсамбуу, 2004). Судалгаанаас харахул 280 хүнийг эс тооцвол нийгмийн гарлын талаар зарим нэг баримтууд байна. Нийтдээ 647 хүнээс 74.9 хувь нь цэвэр малчдын гэр бүлээс гаралтай, 9.2 хувь нь буюу 60 хүн ядуу ардын хүүхэд, 57 буюу 8.8 хувь нь зарцын хүүхэд болж байгаа нь өндөр үзүүлэлт юм. Сэхээтэн, бичээч гаралтай хүн нийтдээ 14 буюу 2.1 хувьтай, бусад нь 1 хувиас бага үзүүлэлттэй байна. Тухайлбал мужаан ба дархан 4 хүн, өртөө улаач 2 хүн, тариачин 10 хүн, анчин 1 хүн, бөө 1, загасчин 1, албат ард 1 зэрэг хүмүүс дурдагджээ. Гэвч угсаа гарал нь тухайн хүний нийгэмд эзлэх социал статусыг тэр бүр тодорхойлж

чадахгүй байх явдал бий. Тэгвэл эдгээр хүмүүсийн өөрсдийнх нь социал статус нь тухайн цаг үедээ ямар байсныг хэрхэн судлах вэ?

Социал статусыг судлахдаа хэрэглэсэн бидний дараагийн арга нь субъектив, шууд бус юм. Энэ нь судлаач тухайн хүний намтар, дурдатгалыг бүхэлд нь уншаад үүний дараа болзмол байдлаар эрх мэдэл, эд хөрөнгө, нэр хүнд гэсэн шалгуураар тухайн үеийн нийгмийг доод, дундаас доогуур, дунд, дундаас дээгүүр, дээд гэсэн таван үндсэн бүлэгт ангилж үзсэн. Ингэхдээ зарим хүмүүсийн намтар, дурдатгал нь аль нэг бүлэгт оруулахад хангалттай биш, итгэлгүй байвал тусад нь мэдээлэл байхгүй гэсэн бүлэг оруулсан. Энэ нь мэдээ занга бүрэн бишээс гадна зарим тохиолдолд партизанууд цаг үетэй нийцүүлж социал статусаа доошлуулж хэлэх хандлага байсан. Мөн судлаачийн хувийн субъектив үзэл туссан байгаа нь эргэлзээгүй. Мэдээж энэ ангилал бол эхний оролдлого яс хатуу тогтсон зүйл биш. Тиймээс дараа дараагийн судлаачид үүнийг нэг бүрчлэн архивийн баримттай тулган нягталж нарийвчлан судлаж алдаа эндэгдлийг залруулах буй заа. Чухам ийм субъектив гэж хэлж болох тооцооллоор партизануудыг ангилж үзэхэд ямар нэгэн байдлаар нийгмийн социал статус нь тодруулах боломжгүй, мэдээлэл байхгүй хүмүүс 291 болж байна.

	Давхраажил	Тоо	Хувь
1	Тодорхойгүй	291	31.4
2	Дээд	1	.1
3	Дундаас дээгүүр	9	1.0
4	Дунд	314	33.8
5	Дундаас доогуур	105	11.3
6	Доод	207	22.3
7	Нийлбэр	927	99.9

Ангиллын дагуу дээд гэсэн давхраанд орох хүмүүс партизануудын дунд байхгүй. Гэсэн хэдий ч тухайн үедээ дээд давхраанд оруулж болохуйц С.Магсаржав, Л.Сумъяа зэрэг цөөнгүй хүн хувьсгалчдын үйл ажиллагаанд гар биечлэн оролцож байсныг марксизмын дараах үеийн монголын түүхийн судалгаа харуулж байгаа.

1913-1915 он хүртэл Хятадын хар цэрэгтэй удаа дараа байлдсан учир гүн хэргэм, засаг тамга, ялгуун баатар цол бейсийн зэргээр шагнагдаж явжээ. 1921 онд ардын журамт цэрэгт хошуу цэргээ адгуулан сайн дураар элсэн орж Түр засгийн газрын гишүүн, дэд жанжин, цэргийн зөвлөлийн гишүүний үүргийг гүйцэтгэж явжээ. (Лаварын Сумъяа, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1986)

Харин партизануудын эмхэтгэлд гүн цолтой 1 л хүнийг албан ёсоор дээд гэсэн ангилалд оруулж болох болов уу. Харин дундаас дээд гэсэн ангилалд багтахуйц сэхээтэн, бичээч гэсэн албан тушаалтай хүмүүс нийтдээ 14 буюу 1.5 хувийг, үүнд тайж, баян айл, бөө мөн зарим нэг бичээчийг оруулбал 9 хүнийг дундаас дээд гэсэн бүлэгт оруулж тооцоолсон байна.

Харин дунд гэсэн шалгуурт 214 хүн буюу 33.8 хувь нь багтсан, голлох хүмүүс нь малчид байжээ.

Би тэр нутагт төрөөд цөөн хэдэн малаа адгуулж хувийн бага шиг газарт улаан буудай, хүнсний ногоо тарьж түүгээр амьдарч явсан юм. (С.Лувсан, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Дундаас доогуур гэсэн ангилалд 105 хүн буюу 11.3 хувь нь багтсан байна.

Манайх хувийн цөөхөн малтай тэр маань амьдралд хүрэлцэхгүй учир бусдын мал хариулах өртөө улаа зарлага хөлсөөр хийх хүн дагаж ан гөрөө хийх зэргээр олон төрлийн ажил хийж амьдарч явлаа. (А.Лувсандорж, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985).

Доод гэсэн ангилалд нийтдээ 207 хүн 22.3 хувийг эзэлж байна. Доод хэсэгт

хамаарч байсан хүмүүсээс биеийн хүчийг үнэлэгч 7 хүн, айлд зарагдаж мал хариулж амь зуудаг, зарц байсан гэж өөрсдийгөө хэлсэн хүмүүс 57, өөрийн хэдэн малтай боловч ядуу амьдарч байсан гэсэн хүмүүс 60, нийтдээ лавтайяа 134 хүн буюу 15 орчим хувь, бусад нь 7.3 хувьтай байна.

Манайхан өвөг дээдсээс уламжилсан ядуу тариачин улс байлаа.(Ж.Нэмэх, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1985).

Мөн биеийн хүчийг үнэлж амьдардаг, доод гэсэн ангилалд орсон нэг хүний жишээг харъя.

Намайг таван настайд эцэг маань нас баржээ. ...бусдын дээл малгайхан оёж шидэж хоёр биеэ тэжээх гэсэн нь олох ашиг хаанаа ч хүрэхгүй даржин ядууд тулж, би хэдий насан бага ч бол тав гурван зоос нэмэрлэхийг горилон бусдын хойно өмнө явж хоёр биеийн хоногийн өл залгахад эхдээ дэм өгөхөөс өөр аргагүйд тулжээ. Ингэж мал нядлан борлуулаачингуудыг дагаж мах хүргэгч болов. (Ш.Лувсанням, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1985)

(Тооцооллоос харахад дундаас доогуур ба доод бүлэг нийлээд бараг гуравны нэгд хүрч байна. Ингэж эл тоо өсөхөд нөлөөлөхөд нөлөөлсөн хүчин зүйл бий юу? Эдгээр дурдатгал нь албан ёсоор социализмын үед бичигдсэн учир социал статус ангилалд оруулах шалгуурын талаархи үнэн бодит мэдээллээ нууж ядуу ардын гэрт төрсөн болгосон, мөн энэ талаар албаар өгүүлээгүй байгааг тооцон үзэх хэрэгтэй. Гэвч аль ч талаас нь аваад үзэхэд малчид хувьсгалын гол хүч болсон гэсэн дүгнэлт хөдөлшгүй үнэн бөгөөд ноттой гэдэг нь харагдаж байна.) Тиймээс олон тохиолдолд энэ хувьсгал бол импортын хувьсгал мөн үү гэсэн асуултанд бид өөрсдийн судалгаан дээр тулгуурлан малчдын хувьсгал гэсэн хариултыг өгч чадахаар байна. Энэ нь монголын хувьсгалд дан ганц дотоод хүчин зүйл шийдвэрлэх нөлөөтэй байсан гэж би хэлэх гээгүй, ямар ч байсан малчид хувьсгалын хөдөлгөгч гол хүч болжээ гэдгийг баталж байна.

4. Хувьсгалын өлгий нутаг аль нь вэ? Хувьсгал эхэлсэн мөн үргэлжилсэн талаар манай эрдэмтэд аль хэдийн өөрсдийн санал дүгнэлт нотолгоог гаргаад байгаа гэдгийг бид өмнөх хэсэгт өгүүлсэн. Нийтдээ хэдэн аймаг хамрагдсан гэдгийг нарийвчлан харуулахыг хичээсэн, (65 хүн аль нутагт төрсөн нь тодорхойгүй байна) (Судалгаанаас харахад хуучин хуваариар партизануудын олонхи нь буюу 43.3 хувь нь Түшээт хан аймгийнх байна). Энэ нь тухайн үедээ газарзүйн байрлалын хувьд гамин бароны хөлд илүүтэй өртсөн, мөн хятадын эсрэг тэмцэж байсан өвөр монголчууд зохион байгуулалтай суурьшсан, мөн их хүрээ буюу улс төрийн төвтэй харьцангуй ойр байсан зэрэг шалтгаан бий. Тэднийг Л.Сумъяа бэйс, Д.Сүхбаатар зэрэг хүмүүс өөрсдөө элсүүлсэн.

Түшээт хан аймгийн Эрдэнэ вангийн хошуу, одоогийн Шаамар сумын нутагт 1882 онд төрсөн. 1921 онд Сүхбаатарын цэрэгт элсэж Хиагт, Нийслэл хүрээг чөлөөлөхөд оролцжээ. (Б.Доржхүү, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1985)

Эндээс журамт цэргийн эх үндэс тавигдсан бөгөөд Д.Сүхбаатар тэргүүтэй хүмүүс Алтанбулаг хотын ойролцоо хилийн харуул, болоод Эрдэнэ ван, Сумъяа бэйс, Уялга, Хяраан, Харуул, Хүдэр, Харуул зэрэг газраас анхны цэргийг бүрүүлжээ. Ялангуяа Сумъяа бэйсийн хошуу нь ардын журамт цэргийн суурь болсон нь Дээд Шивээтэй, Оросын хилтэй ойр, зэвсэг нийлүүлэхэд хялбар, мөн гамин цэргээс нуугдаж хил давахад ч тохиромжтой байжээ. Мэдээж Л.Сумъяа бэйс бол Зүүн Монголын хүн бөгөөд Шинжаан нутагтаа Манж-Хятадын эсрэг хөдөлгөөн өрнүүлж тэдний дотор урвалт гарснаар хятадын цэрэгт дарагдан Орос нутагт нутгийн 200 өрхийн хамт гарч улмаар Алтанбулагаар дамжин ирж Богд хаанд дагаар орсон байжээ.

1918 оны байдлаар Засагт хан аймаг 16407 буюу хамгийн цөөхөн хүнтэй аймагт тооцогдож (З.Лонжид, XX зууны эхэн үеийн монголын нийгэм эдийн засгийн төлөв байдал, 1995) байсан боловч нийт партизануудаас 135 нь буюу 14.5 хувийг эзэлж хоёрдугаарт орж байна. Ялгаатай нь засагт ханы цэргүүд гол төлөв цэрэг татлагаар элсэж С.Магсаржавын удирдлаганд байлджээ.

Засагт ханы Дархан бээлийн хошуу, одоогийн Ховд аймгийн Цэцэг сумын Цэцэг голд 1901 онд төржээ. 1921 оны наймдугаар сард ...Хатанбаатар Магсаржавын ангид нэгэн аймаг, хошууны олон эрсийн хамт элсэн оров. (Ц.Даваажав, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1982)

Уг нь 1918 онд Сайн ноён хан аймаг 30651 хүнтэйгээрээ бусад аймгийг тэргүүлж байжээ. (З.Лонжид, XX зууны эхэн үеийн монголын нийгэм эдийн засгийн төлөв байдал, 1995) Партизануудаас 135 хүн буюу 14.5 хувь нь Сайн ноён хан аймгийн хүмүүс байгаа нь Засагт ханыхтай яг ижил байна.

Сайн ноён хан аймаг хошууны ...Жирэгтэй зэргэмж газар алба залгуулж байв. 1921 он гарав. ...Сүхбаатар нар хойд хилийн харуулуудаас журамт цэрэг элсүүлэв. ...сайн дураараа элсэн оров. (Г.Дамба, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Сэцэн хан аймгийн харьяалалтай хүмүүс 101 хүн буюу 10.9 хувьтай байна. Тэд Бумцэнд, Дугаржав нарын цэрэгт голдуу элсжээ.

1921 он ...зүүн өмнө хязгаар нутагт дээрэм тонуул хийж яваа... сарнимал цагаантантай байлдаж устгахаар Хүрээ их цэрэг Сэцэн ханы хүрээнд ирлээ... Сэцэн хан аймаг Зүүн өмнө ба Зүүн хязгаарыг хамгаалан тохинуулах сайд бөгөөд ардын цэргийн ...дарга Магсаржавын Дугаржав, хорооны дарга хурандаа Бумцэндийн цэргийн ...жагсаалд багтсан (Л.Цэнд, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1986)

Мөн Дөрвөд далай хааны хошуунаас ч цагаантны эсрэг хийх тэмцэлд иргэд нэгдэн орсон.

...Хасбаатар "Бид ар Хиагтаас гарсан. Танай нутагт бугшсан цагаан цэргийг хөөж гаргахаар яваа юм. ...хэдэн хань элсүүлж аваад бидэнтэй нийлэхгүй юу" ..би тэндээс гэртээ ирж байгаад сүүлдээ Хойлогийн ширэг дээр очиж цэрэгт орлоо. (Т.Хөх, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1986)

Хүснэгтээс харахад 14 хүн буриад гаралтай байна.

ЗСБНАБуриад улсын нутагт төржээ. 1921 оны эхээр Сүхбаатар Дээд алтан гэдэг газар ирж Мааньтын голын баруун талд өвөлжиж байсан Сумъяа бээсээр тэргүүлүүлэн тавин цэрэг элсүүлэв. (Ч.Доржпалам, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1985)

Харин Нийслэл хүрээ хавиас 19 хүн журамт цэрэгт элсэн оржээ.

Хуучин нийслэл Хүрээ, одоогийн Улаанбаатар хотод 1901 онд төржээ. 1921 онд Сүхбаатарын цэрэгт элсэн орж, Хиагт зэрэг газар гэмин, цагаантантай байлдахад оролцож явсан байна. (Б.Цэрэндоо, Ардын журамт цэргийн дуртгалууд., 1982)

Тухайн оршин суугаа газраасаа цэрэгт элсэхээс гадна цөөнгүй хүн янз бүрийн шалтгаанаар өөр аймаг хошуунд явж байгаад тэндээсээ цэрэгт элсжээ. Тиймээс үүнийг нарийн ялган салгахын тулд цэрэгт татагдах үедээ өөрийн нутагтаа амьдарч байсан уу, эсвэл өөр газар явж байсан уу? гэсэн асуултыг бид дурдатгалаас судласан.

	Нутагтаа амьдарч буй эсэх	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	О	271	29.2	0	0
2	Тийм	541	58.3	541	83
3	Үгүй	115	12.4	115	17
4	Нийлбэр	927	99.9	656	100

Энэ асуудалтай холбоотой мэдээлэл 656 хүнд байгаа нь нийтдээ 70 хувьд хүрнэ. Мэдээлэл байгаа хүмүүсийн 83 орчим хувь нь цэрэгт явахын өмнө нутагтаа амьдарч байсан гэж хариулсан байхад, 17 орчим хувь нь буюу 115 хүн өөр хошуу нутагт явж байгаад цэрэгт элсжээ. Бидний дурдах жишээ бол Сэцэн хаан аймгийн хүн Хүрээнд явж байгаад журамт цэрэгт элссэн гэдгийг өгүүлнэ.

1918 онд Сан бейсийн хошуунаас богдод мөргөхөөр ирсэн мөргөлчний тэрэг хөтөлж буцалгүй үлдэв. ..амьдрахын эрхээр Орхон, Шаамар гэдэг газар очиж айлаар хэсэж байгаад ...Сүхбаатар хүрэлцэн ирж идэр залуучуудыг сайн дураар цэрэгт элсүүлсэн ба ... элссэн юм. (А.Цогт, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1986)

Мөн Нийслэл хүрээнд ирж байж байгаад цэрэгт элсэн орсон хүн ч бий.

1921 оны зун нийслэл Хүрээг ардын журамт цэрэг чөлөөлсний дараа би хөдөөнөөс ирээд Хүрээнд хэд хонож байтал нэг өдөр Сүхбаатар жанжинтай тохиолдов. Сүхбаатар намайг ямар хэрэгтэй хотод ирснийг асуугаад чи одоо Сангийн яаман дээр байгаа цэрэг дээр түр очиж бай. Дараа чамайг ажилд томилно гэв. (Г.Чойдог, Ардын журамт цэргийн дуртгалууд, 1986)

Дээрх баримт нь Гамин, Бароны цэрэгт улс амьтан ихээхэн дүрвэж, дотоод шилжих хөдөлгөөн өндөр байсантай мөн, нөгөө талаас партизанууд санаандгүй явж байгаад хувьсгалчидтай нийлж байсныг харуулна. Бид шинэ засаг захиргааны нэгжээр ангилан үзсэн нь билээ.

	Аймаг одоогоор	Тоо	Хувь
1	0	91	9.8
2	Гүйлддаа	1	.1
3	Өвөрхангай	11	1.2
4	Баян-Өлгий	14	1.5
5	Архангай	17	1.8
6	Говь-алтай	61	6.6
7	Бичуриний район	1	.1
8	Амгаланбаатар	1	.1
9	Дорнод	50	5.4
10	Дорноговь	9	1.0
11	Өмнөговь	5	.5
12	Булган	78	8.4
13	Дундговь	8	.9
14	Завхан	108	11.6
15	Сүхбаатар	15	1.6
16	Сэлэнгэ	256	27.6
17	Увс	7	.8
18	Улаанбаатар	22	2.4
19	Ховд	49	5.3
20	Хэнтий	24	2.6
21	Төв	70	7.5
22	Хөвсгөл	29	3.1
23	Нийлбэр	927	99.9

Шинжилгээнээс харахул Сэлэнгээс хамгийн олон партизан буюу бараг 4 хүн тутмын нэгээс илүү нь буюу 27.6 хувь нь Сэлэнгээс гаралтай байхад, 11.6 хувиар Завхан аймаг удаалж байна. Энэ нь нийт партизануудын 10 хүн тутмын нэг нь Завханых гэсэн үг юм. Булган нутгаас 78 хүн буюу 8.4 хувь, Төв аймаг 70 хүн буюу 7.5 хувь, Говь-Алтай аймаг 61 хүн буюу 6.5 хувь, Дорнод аймаг 50 хүн буюу 5.4 хувь, Ховд аймаг 49 хүн буюу 5.3 хувь, Хөвсгөл аймаг 29 хүн буюу 3.1 хувь тус тус орсон байна. Мөн Хэнтий, УБ, Увс, Сүхбаатар, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Өвөрхангай, Архангай, Баян-Өлгий зэрэг аймгуудаас партизанууд төрч гарчээ. Харин 91 хүн буюу 9.8 хувь нь шинэ засаг захиргааны хуваарийн ангилалд алинд орох талаар дурдатгалд баттай мэдээ алга байна.

Дээрх баримтыг харахад Баянхонгор аймгаас бусад нь хамгийн доод тал нь 5, хамгийн дээд тал нь 256 хүн хувьсгалд оролцжээ.

Аймгуудаас хувьсгалд оролцсон хүмүүсийн тоо жигд тархсан, нийгмийн бүхий л давхрааны хүмүүс байгааг үндэс болговол 1921 оны үндэсний ардчилсан хувьсгал нь монголчуудын өөрсдийн идэвхи санаачлагаар өрнөсөн эрх чөлөөний төлөө жам ёсны тэмцэл байсан гэдгийг нотолж байна.

(Үргэлжлэл бий. Энэхүү судалгааны үр дүн нь 4 цуврал өгүүлэл болж нийтлэгдэх бөгөөд хоёрдахь хэсэг нь Социологи сэтгүүлийн 8-р дугаарт хэвлэгдэн гарах болно.)

Ном зүй

1. Ардын журамт цэргийн дурдатгалууд. (1962). УБ.
2. Ардын журамт цэргийн дурдатгалууд. (1969). УБ.
3. Ардын журамт цэргийн дуртгалууд. (1982). УБ.
4. Ардын журамт цэргийн дуртгалууд. (1985). УБ.
5. Ардын журамт цэргийн дуртгалууд. (1986). УБ.
6. Л.Бат-Очир. (1999). Түүхийн үнэний эрэлд. УБ.
7. Ж.Болдбаатар. (1999). Монголын түүхийн судалгаа-сургалтын онол-арга зүйн өнөөгийн төлөв байдал, цаашдын хандлага. In *Түүхийн судалгааны онол-арга зүйн асуудал* (pp. 6-25). УБ.
8. Ж.Болдбаатар Монголын ойрхи түүхийн зангилаа асуудал.//*Түүх зулсан он жилүүдийн ойллого. 1-р боть. 2003.*
9. Ч.Болдбаатар. (2004). XX зууны Монголын улс төрийн зүтгэлтнүүд. УБ.
10. Э.Гидденс. (2006). Социологи.УБ., Адмон.
11. Х.Гүндсамбуу. (2004). XX зууны Монголын нийгмийн давхраажил хөгжил хандлага. УБ.
12. Д.Г.Гумилёв. (1995). Хар домог. УБ.
13. Б.Даваасүрэн. (1999). Монголын зэвсэгт хүчний үүсэл, хөгжлийг түүх шинэчлэлийн үүднээс үзэх нь. XX зууны монголын түүхийн зангилаа асуудал, УБ.
14. Ш.Паламдорж. (2001). Хоёрдугаар зууны Монголын цэрэг. Улаанбаатар.
15. О.Латимор. (1992). Нүүдэлчид ба хувьсгалчид. УБ.
16. О.Латимор. (1994). Нүүдэлчид ба хувьсгалчид. УБ.
17. З.Лонжид. (1995). XX зууны эхэн үеийн монголын нийгэм эдийн засгийн төлөв байдал. In *XX зууны Монгол* (p. 129). УБ: Эрдэм.
18. З.Лонжид. (2002). Монголын гурван хувьсгал ба лам нар. *Монголын үндэсний хувьсгалын түүхийн асуудал.*
19. О.Мөнхбат. (2002). О.Контын социологийн үзэл баримтлал. *Социологи №2*, МУИС-ийн ЭШС.
20. В.Отгоннасан. (2004). Олны санаа оломгүй далай. УБ.
21. А.Роберт, Р. (2000). Хоёрдугаар зууны монголчууд. УБ: Адмон.
22. Н.Смелзер. (2001). Социологи. Улаанбаатар: ШУА.
23. Ч. Тамир. (2002). Түүхийн социологи: өнөөгийн байдал, цаашдын хандлага. *Социологи №2*, МУИС-ийн ЭШС.
24. Ч.Тамир. (2003). Улс төрийн социологийн онол арга зүйн асуудалд. *Социологи. № 4*. МУИС-ийн ЭШС.
25. Ч.Тамир (2003). «Ардын зарга нь Монголчуудын улс төрийн оролцооны уламжлалт хэлбэр мөн» //Түүх № 2, МУИС-ийн ЭШС
26. Ч.Тамир, Р.Төрдалай. (2005). «Монгол заргын бичиг: Судалгааны арга зүй, аргачлалын асуудал» // *Acta Mongolia* (Dedicated to the 100th Birthday of professor Ycngsiyebь Byambyin Rinchen (1905-1977)), МУИС. Монгол судлалын төв. ЭШБичиг
27. Н.Хишигт. (2001). 1921 оны ардын хувьсгал ба ардын журамт цэрэг. УБ.
28. Н.Хишигт. (1992). Ардын журамт цэргийн дурдатгалууд бол хувьсгалын түүх судлалын чухал эх сурвалжийн нэг мөн. *Олон улсын Монголч эрдэмтэдийн 5-р их хурал. 1-р боть.* УБ.
29. Б.Ширэндэв. (1969). Монгол ардын хувьсгалын түүх.УБ